



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/384

Мандалговь

Үлийн цагаан оготонотой тэмцэх
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-ийн "7", "9", "10", Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтууд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/303 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан, Дэрэн, Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан, Сайхан-Овоо сумдын нийт 50,0 мян.га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготонотой энгийн механик аргаар тэмцэх ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 10 хоногт багтаан зохион байгуулсугай.

Хоёр. Засгийн газрын 185 дугаар тогтоолын дагуу "Бэлчээр хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сум бүрт зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, үлийн цагаан оготонотой тэмцэх ажилд албан байгууллага, ард иргэдийг оролцуулан гүйцэтгүүлж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдөн, батлагдсан төсөвт багтаан, хугацаанд нь чанартай, үр дүнтэй зохион байгуулж тайлагнаж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Дөрөв. Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, гүйцэтгэсэн ажлын тайланг товлосон хугацаанд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхжаргалд хариуцуулсугай.

Тав. Ажлын явцад байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т үүрэг болгосугай.

Зургаа. Үлийн цагаан оготонотой тэмцэх ажилд хамрагдах сумдын нэр, талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.


ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

488191093

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын 29-ний өдрийн 1384 дугаар
захирамжийн хавсралт



БЭЛЧЭЭРИЙН ҮЛИЙН ЦАГААН ОГОТОНТОЙ ЭНГИЙН МЕХАНИК АРГААР
ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ СУМДЫН ТЭМЦЭХ ТАЛБАЙН
ХУВААРЬ

Д/д	Сумдын нэр	Тэмцэх талбайн хэмжээ мян/га
1	Эрдэнэдалай	10,000
2	Адаацаг	7,000
3	Дэлгэрцогт	7,000
4	Дэрэн	8,000
5	Баянжаргалан	2,000
6	Сайнцагаан	7,000
7	Говь-Угтаал	4,000
8	Гурвансайхан	3,000
9	Сайхан-Овоо	2,000
	Нийт	50,000